

## ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2017 ОНЫ ТӨСӨЛ, 2018-2019 ОНЫ ТӨСӨӨЛӨЛ БОЛОВСРУУЛСАН ДҮНГИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

Мэдээлэгч нь : П.Амгаланбаатар  
/ Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /

Орон нутгийн төсвийн орлого, зарлага, ОНХС, орон нутгийн хөрөнгө оруулалтын 2017 оны төсөл, 2018-2019 оны төсөөллийг боловсруулсан дүнг хэлэлцүүлэхээр та бүхэнд өргөн барьж байна.

Төсвийн ажиллагааны төслийг боловсруулахад аймаг, сумдын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, харьяа салбар, бодлогын өдөр тутмын бодлого ирэх 3 жилд хэрэгжүүлэх бодлогын чиглэл, зорилтоо бодитой тодорхойлон иргэд, олон нийтээр хэлэлцүүлэн ач холбогдлоор нь эрэмбэлэн хөтөлбөр, арга хэмжээнд суурилсан байдлаар боловсруулан 8-р сарын 1-ны дотор ирүүлэх талаар нийт, ажилтан, албан бичиг төсвийн төсөл боловсруулах ажлыг зохион байгууллаа.

Төсвийн төсөл боловсруулах талаар заавар, зөвлөмж өгч ажиллаж байгаа хэдий ч зарим сумдын ТЭЗ, төсвийн байгууллагуудын захирагч, удирдлагууд энэ ажилд идэвх санаачлага гаргахгүй, сум, орон нутгийнх нь хөгжлийн бодлого, зорилт тодорхой бус байгаа.

Монгол улсын Засгийн газрын болон аймаг, сумдын хөгжлийн хөтөлбөр, аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн үндсэн зорилтуудыг хангахад шаардагдах зардлыг Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн төсвийн аргачлал”, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”, 2015 оны 7 дугаар тушаал “Эдийн засгийн ангилал батлах тухай”, Сангийн яамны удирдамж, бусад хууль эрх зүйн акт, одоогийн мөрдөгдөж байгаа үнэ ханшийн хүрээнд төсвийн захирагч нарын саналыг үндэслэн боловсрууллаа.

Сум, төсөвт байгууллага, агентлаг, хэлтсүүдээс ирүүлсэн орон нутгийн төсвийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын 2017 оны, 2018-2019 оны дунд хугацааны төсөл боловсруулсан дүнг танилцуулья.

### Нэг. Төсвийн орлогын талаар

Ирэх 2017 оны төсвийн төсөлд орон нутгийн төсвийн нийт орлогыг 7494.9 сая төгрөг байхаар тооцож, үүний 91.0 хувь буюу 6820.6 сая төгрөгийг татварын орлогоор, 8.4 хувь буюу 530.9 сая төгрөгийг татварын бус орлогоор, 0.6 хувь буюу 50.0 сая төгрөгийг хөрөнгийн орлогоор бүрдүүлэхээр төлөвлөв.

Ирэх оны урсгал орлогыг 7494.9 сая төгрөг байхаар төлөвлөсөн нь 2015 оны гүйцэтгэлээс 10.1 хувиар, 2016 оны төлөвлөгөөнөөс 24.7 хувиар тус тус буурахаар, хүлээгдэж буй гүйцэтгэлээс 3.1 хувиар өсөхөөр төлөвлөв.

Татварын орлогыг татварын хэлтсээс ирүүлсэн төслийн санал, урьд оны гүйцэтгэл, тайлант оны төлөвлөгөө, хүлээгдэж буй гүйцэтгэлийг сумдын саналтай харьцуулан боловсруулав.

Сүүлийн жилүүдэд төсвийн орлогыг аймгийн ИТХ-р 2,7 тэрбум орчим төгрөгөөр нэмэгдүүлсэнээс төсвийн орлого тасарч, зарлагыг санхүүжүүлэх эх үүсвэр дутагдаж байсан тул энэ төсөлд бодит татварын бааз суурьт үндэслэн боловсруулсан болно.

Тухайлбал ИХШХЕГ-ын харьяа Ховд аймгийн салбараас сүүлийн жилүүдэд баруун 5 аймгийн визны хурамжаар улсын тэмдэгтийн болон хүү торгуулийн орлогод 800,0 сая төгрөг жил бүр төсөвт оруулж байсан бол 2016 оноос визны журамд өөрчлөлт орж уг орлого аймаг аймагтаа ордог болсон тул орлогыг бууруулж төлөвлөв.

Ноосны урамшууллаар урьд онуудад 2,0 төгрөгөөр тооцож урамшуулал олгож байсныг 2016 оноос 1,0 төгрөгөөр тооцож төсөвт оруулж байгаагаас үйл ажиллагааны орлого 100,0 орчим сая төгрөгөөр буурсан.

Цалин хөлс түүнтэй адилтгах орлогод өмнөх онуудад эдийн засаг тааламжтай байхад хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын хөлснөөс татвар нилээд орж байсан боловч 2016 оноос орлого буурч байгаатай холбогдон энэ татвар буурч байна.

Ирэх оны төсвийн нийт орлого тусламж 68772.0 сая төгрөг байхаар тооцож, үүний 10.9 хувь буюу 7494.9 сая төгрөгийг орон нутгийн төсвийн орлогоор, 19.7 хувь буюу 13638.8 сая төгрөгийг санхүүгийн дэмжлэгээр, 62.9 хувь буюу 43218.4 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээр, 6,5 хувийг буюу 4419,9 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгээр тус тус санхүүжүүлэхээр төлөвлөв.

### **Хоёр. Төсвийн зарлагын талаар**

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.4 дэх заалтын дагуу Сангийн яам Засгийн газрын баталсан 2017 оны төсвийн хязгаарыг богино болон дунд хугацааны төсвийн төсөл боловсруулах удирдамжийн хамт ирүүлсэн юм.

Монгол Улсын Их Өбдөө, Засгийн газар төсвийн хүрээний мэдэгдлүүд 2017 î î î хязгаарыг батлан манай аймагт урсгал зардалд санхүүгийн дэмжлэгээр 7548,7 сая төгрөг олгохоор тооцож ирүүлсүй нь 2016 оны хэмжээнд байхаар байна.

Ирэх 2017 онд орон нутгийн төсвийн суурь урсгал зарлага 21040.4 орон нутагт чиг үүрэг нь шилжиж ирсэн төсвийн байгууллагуудын төсвийн суурь урсгал зарлага 43311.7, нийт суурь урсгал зарлага 64361,2 сая төгрөг байхаар төсөвлөсөн нь 2015 оны гүйцэтгэлээс 12,1 тэрбум, 2016 оны төлөвлөгөөнөөс 9,6, хүлээгдэж буй гүйцэтгэлээс 7,1 тэрбум төгрөгөөр өсөхөөр байна.

Орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэх 2017 оны урсгал зардал 2015 оны гүйцэтгэлээс 17,4 хувиар, 2016 оны төлөвлөгөөнөөс 22,2 хувиар, хүлээгдэж буй гүйцэтгэлээс 10 хувиар тус тус өсөхөөр төлөвлөгдөв.

Орон нутгийн төсвийн урсгал зардлын 33,0 хувийг ажиллагсадтай холбогдсон зардал, 26,8 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 40,2 хувийг татаас ба урсгал шилжүүлгийн зардал тус тус эзэлж байгаа нь 2016 оны төлөвлөгөөнөөс ажиллагсадтай холбогдсон зардал 13,1, бараа үйлчилгээний бусад зардал 69,7, татаас ба урсгал шилжүүлгийн зардал 9,0 хувиар тус тус өсөхөөр байна.

Орон нутгийн төсвийн байгууллагуудын 2016 оны төсвийн урсгал зарлагыг 10 орчим хувиар, бараа, үйлчилгээний бусад зардлыг сүүлийн 2 жил дунджаар 60 гаруй хувиар, тэтгэмж, урамшууллын зардлыг 100 хувь тус тус бууруулсаныг 2017 оны төсвийн төсөлд бодит байдлаар тусганаас шалтгаалан дээрх өсөлт хийгдсэн юм.

Төсвийн  $\text{ààéãóëëàãóáä}$   $\text{òãõí èê}$ , тоног төхөөрөмжөөр нилээд  $\text{òàí ääãàí}$   $\text{àø èãèàõ}$   $\text{áí èñí í}$ , өндөр  $\text{yóëùí}$   $\text{áçñ}$ эд оршдог тул  $\text{ì àø èí ù}$   $\text{yáãðýè}$   $\text{èðòýé}$ ,  $\text{äóãéíý}$   $\text{í í ðì}$   $\text{ãéóäýãé}$   $\text{çýðãýñ}$  шалтгаалан бичиг хэрэг, шатахуун, машины сэлбэгийн зардал хүрэлцдэггүй тул уг зардлуудыг бодит байдлаар тооцон төсөлд тусгалаа.

Сумдын ИТХ, ЗДТГ, Багийн төсөвт интернетийн болон модемийн эрх сунгах зардал, байгууллагуудын төсөвт төрийн үйл ажиллагааг ил тод нээлттэй мэдээлж байгаатай холбогдон мэдээлэл сурталчилгааны зардал, шинээр хог хаягдлын татвар авах болосонтой холбогдон хог хаягдлын татвар, зардал, компьютер, техник хэрэгслийн засвар, вирусн програмын зардлыг эдийн засгийн шинэ ангиллын дагуу нэр зааж тусгав.

Жаргалант сумын 2810 ахмад настан, 1048 гаруй хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд унааны хөнгөлөлтөнд 40,4, Засгийн газрын 2012 оны 209 дүгээр тогтоолоор гэр хорооллын иргэдийн усны үйлчилгээний төлбөрийг хөнгөлөхөд 186,0, байгаль хамгаалах санг 120,0 сая төгрөг байхаар тооцон төсөлд тусгав.

ХАА-н салбарын төсөвт урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд давхардсан тоогоор 2421,6 мянган малд 751,8  $\text{ñàý}$  төгрөг тусгав.

Орон нутагт чиг үүрэг нь шилжиж ирсэн төсвийн байгууллагуудын төсвийн суурь урсгал зарлага 43311.7 сая төгрөг байхаар төсөвлөсөн нь 2015 оны гүйцэтгэлээс 7,6 тэрбум, 2016 оны төлөвлөгөөнөөс 5,7, хүлээгдэж буй гүйцэтгэлээс 5,0 тэрбум төгрөгөөр өсөхөөр байна.

Боловсролын салбарт ирэх 2017 онд төрийн 29, хувийн хэвшлийн 13 цэцэрлэгийн 187 бүлэгт өдрийн 4863, ээлжийн, явуулын, нүүдлийн сургалтаар 1783 хүүхэд, 24 ЕБС-д 19108 хүүхэд, 17 дотуур байранд 2423 хүүхэд сурч хүмүүжүүлэхэд нийт 38.0 тэрбум төгрөг байхаар тооцсон нь 2015 оны гүйцэтгэлээс 21.4 хувиар, 2016 оны төлөвлөгөөнөөс 16.5 хувиар, хүлээгдэж буй гүйцэтгэлээс 14.1 хувиар тус тус өсөхөөр төлөвлөлөө.

Засгийн газрын 2016 оны 242 дугаар тогтоолоор СӨБ, ЕБС-ийн хувьсах зардлыг тооцоход бодит зардлаас бага гарч байгаа тул хувьсах зардлыг зохих хэмжээгээр нэмэгдүүлэн шинээр ашиглалтанд орох барилга, байгууламжын ашиглалттай холбогдсон зардлыг нэмж төсөлд тусгав.

Эрүүл мэндийн салбар нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээг нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээний хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллана.

Ирэх онд эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтүүдийг 1 янганы хөгжлийн зорилтод хүргэх, нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээг өргөжүүлэн, өвчлөхөөс өмнө урьдчилан сэргийлэх бодлогыг бүх шатны байгууллагуудад хэрэгжүүлэх зорилт тавьж байна. Дээрх хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхэд 4.6 000000 төгрөг зарцуулагдахаар байгаа нь 2015 оны гүйцэтгэлээс 17.9 хувиар, 2016 оны төлөвлөгөөнөөс 4.5 хувиар, хүлээгдэж буй гүйцэтгэлээс 2.3 хувиар тус тус өсөхөөр төлөвлөлөө.

Сумдын эрүүл мэндийн төвийн төсвийн төлөвлөлтийг Эрүүл мэнд, спортын сайд, Сангийн сайдын хамтарсан 2015 оны 498/345 дугаар тушаалын дагуу “Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн санхүүжилтийн аргачлал батлах тухай” зааврын дагуу боловсруулав.

Энэ аргачлалаар тооцсоноос хойш эрүүл мэндийн төвийн төсөв харьцангуй нэмэгдэж ирсэн тул 2016 онд төсвийн хүндрэл багатай байгаа юм.

Соёлын салбар нь соёл, урлагийг баруун монголын үндэстэн ястны онцлогт тулгуурлан хөгжүүлэх, үйлчилгээг өргөжүүлэх, хадгалж, хамгаалахад чиглэгдсэн зорилтуудыг хэрэгжүүлэхэд 2017 онд 2,4 тэрбум төгрөг төлөвлөсөн нь 2015 оны гүйцэтгэлээс 40,6 хувиар, 2016 оны төсвөөс 25,2 хувиар, хүлээгдэж буй гүйцэтгэлээс 20 хувиар тус тус өсөхөөр төлөвлөлөө.

Ирэх 2017 оны төсвийн төслийг байгууллага бүр цахим програмаар интернетийн сүлжээг ашиглан шивж оруулж байгаа тул төсөв оруулж буй сайт гацах, тасрах нилээд хүндрэл гарч байна.

Орон нутагт чиг үүрэг нь шилжиж ирсэн байгууллагуудын төсвийн төслийг холбогдох байгууллагуудаас хянан хүлээн авч нэгтгэн холбогдох яамдууд нь хүргүүлж байна.

Гурав. Хөрөнгө оруулалтын талаар

Хөрөнгө оруулалтын төсвийн төслийг боловсруулахдаа аймаг, сумдын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Аймгийн ИТХ-ын төлөөлөгчид, сум байгууллагуудын болон Засаг даргын Тамгын газрын хэлтэс, агентлагуудын салбарын бодлоготой уялдсан саналыг үндэслэн нэн тэргүүний тулгамдсан хөгжлийн хөрөнгө оруулалтын асуудлыг нэгтгэн боловсруулж ирэх 2017 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтанд .....тэрбум, ОНХС-ийн хөрөнгө оруулалтанд 4.4 тэрбум, замын сангийн хөрөнгө оруулалтанд 345,0 сая, улсын төсвийн хөрөнгө оруулалтанд.138.8 тэрбум төгрөг байхаар тус тус төлөвлөлөө.

Орон нутгийн болон орон нутагт чиг үүрэг нь шилжиж ирсэн төсвийн байгууллагуудын 2017 оны төсвийн төсөл, 2018-2019 оны төсөөллийн саналыг хэлэлцэн санал, хүсэлт гарган дэмжиж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ОРОН НУТГИЙН БОЛОН ОРОН НУТАГТ ЧИГ  
ҮҮРЭГ НЬ ШИЛЖИЖ ИРСЭН ТӨСВИЙН  
БАЙГУУЛЛАГУУДЫН 2017 ОНЫ ТӨСВИЙН  
ТӨСӨЛ, 2018-2019 ОНЫ ДУНД ХУГАЦААНЫ  
ТӨСӨӨЛӨЛ

САНХҮҮ ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭС  
2016.08.06